

**БАНКИНД УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ  
АРГА ХЭМЖЭЭ АВАХ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ЖУРАМ****НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

- 1.1. Энэхүү журмын зорилго нь Монголбанкнаас банкинд урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх үндэслэлийг тогтоох, урьдчилан сэргийлэх арга хэмжээг авах шийдвэр гаргах, шийдвэрийн хэрэгжилтийг хангах, дуусгавар болгох болон тэдгээртэй холбогдох бусад харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. Монголбанкнаас банкинд авах урьдчилан сэргийлэх арга хэмжээ нь хадгаламж эзэмшигч, харилцагчийн эрх ашгийг хамгаалах, банк төлбөрийн чадваргүй болох гарцаагүй нөхцөл байдал үүсэх, хэвийн үйл ажиллагаа алдагдахаас урьдчилан сэргийлэх зорилготой байна.
- 1.3. Энэхүү журамд заасан урьдчилан сэргийлэх арга хэмжээ гэдэгт Банкны тухай хуулийн 48 дугаар зүйлд заасан урьдчилан сэргийлэх арга хэмжээ, уг арга хэмжээний хүрээнд Банкны тухай хуулийн 27 дугаар зүйл, 36.4 дэх хэсэг, 43.2.12-т заасныг тус тус үндэслэн гаргасан Монголбанкны шийдвэр хамаарна.
- 1.4. Монголбанк банкинд урьдчилан сэргийлэх арга хэмжээг авахдаа Банкны тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2 дахь хэсэгт заасны дагуу тухайн зөрчил, дутагдал, үүссэн нөхцөл байдал, шаардлагад тохирсон арга хэмжээ авах зарчмыг баримтална.
- 1.5. Энэхүү журам нь Төв банк (Монголбанк)-ны тухай хууль, Банкны тухай хууль, Захиргааны ерөнхий хууль, Зөрчлийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжтой нийцтэй байна.
- 1.6. Банкнд авах урьдчилан сэргийлэх арга хэмжээнээс бусад албадлагын арга хэмжээ авах харилцааг Монголбанкнаас баталсан холбогдох журмаар зохицуулна.
- 1.7. Банкнд урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах шийдвэрийн төслийг Банкны хяналт шалгалтын хорооны хурлаар хэлэлцүүлэхтэй холбоотой харилцааг Монголбанкны Ерөнхийлөгчийн баталсан журмаар зохицуулна.
- 1.8. Банкны тухай хуулийн 48.1.14-т зааснаас бусад тохиолдолд банкинд урьдчилсан сэргийлэх арга хэмжээг аливаа дараалал харгалзахгүйгээр авна.
- 1.9. Монголбанкны Ерөнхийлөгч, хянан шалгагч, улсын байцаагчийн эрх бүхий албан тушаалтан (цаашид хамтад нь “Улсын байцаагчийн эрх бүхий албан тушаалтан” гэх) Төв банк (Монголбанк)-ны тухай хууль, Банкны тухай хууль тогтоомжид заасны дагуу банкинд урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.
- 1.10. Монголбанк нэг банкинд хэд хэдэн эсхүл нэгэн зэрэг зөрчил гаргасан банкинд хамтатган урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч болно.
- 1.11. Монголбанк нэг ижил зөрчил гаргасан банкуудад ижил арга хэмжээ авна.
- 1.12. Монголбанк нэг зөрчилд авсан арга хэмжээний дараа зөрчлийн байдал сайжраагүй тохиолдолд тус арга хэмжээг давтан авахгүй бөгөөд дараагийн шатны арга хэмжээг авна.
- 1.13. Гадаадын банкинд урьдчилан сэргийлэх арга хэмжээ авахад Монголбанк болон харьяалах улсын хяналт шалгалтын эрх бүхий байгууллагын хооронд байгуулсан

“Харилцан ойлголцлын санамж бичиг”-т өөрөөр заагаагүй бол энэ журмыг баримтлана.

- 1.14. Монголбанк, Улсын байцаагчийн эрх бүхий албан тушаалтнаас зөрчил шалган шийдвэрлэхтэй холбоотой харилцааг энэ журмаар зохицуулахгүй.

## **ХОЁР. УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭ АВАХ ҮНДЭСЛЭЛ, ШИЙДВЭР ГАРГАХ АЖИЛЛАГААГ ЭХЛҮҮЛЭХ**

- 2.1. Монголбанкнаас банкинд урьдчилан сэргийлэх арга хэмжээ авахдаа Банкны тухай хуулийн 48.1-т заасан дараах нөхцөл байдал үүссэн эсэхийг урьдчилан тогтоосон байна:
- 2.1.1. Монголбанкнаас тогтоосон дүрэм, журам, шийдвэрийг зөрчсөн;
- 2.1.2. Монголбанкнаас тогтоосон дүрэм, журам, шийдвэрийг зөрчиж болзошгүй нөхцөл байдал үүссэн;
- 2.1.3. Банкны тусгай зөвшөөрлийн шаардлагыг хангаагүй;
- 2.1.4. Найдваргүй, хэвийн бус үйл ажиллагаа явуулсан;
- 2.2. Монголбанкнаас тогтоосон дүрэм, журам, шийдвэрийг зөрчиж болзошгүй нөхцөл байдал үүссэн гэдэгт банк Банкны тухай хууль болон Монголбанкнаас тогтоосон банкны үйл ажиллагааны үзүүлэлт, шаардлага, харилцагчийн өмнө хүлээсэн үүргээ хууль буюу гэрээнд заасан хугацаанд биелүүлэх боломжгүйд хүргэх банкны санхүүгийн үзүүлэлт буурч, эрсдэлийн түвшин нэмэгдэж байгааг ойлгоно.
- 2.3. Монголбанкнаас тогтоосон дараах дүрэм, журам, шийдвэрүүд зөрчигдсөн эсхүл зөрчигдөж болзошгүй нөхцөл үүссэн тохиолдолд Банкны тухай хуулийн 48.1-т заасан арга хэмжээг Хавсралт 3-ын дагуу харгалзах түвшний эсхүл түүнээс дээш түвшний арга хэмжээг заавал авч хэрэгжүүлнэ:
- 2.3.1. Монголбанкнаас тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг хангаагүй эсхүл хангахгүй байх нөхцөл үүсч болзошгүй;
- 2.3.2. Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журмын дагуу активыг ангилж холбогдох эрсдэлийн санг дутуу эсхүл байгуулаагүй нь тогтоогдсон;
- 2.3.3. Банкны үйл ажиллагаанд тавих хязгаарлалтыг тооцох, хангах, тайлагнах, хяналт тавих журмаар тогтоосон хязгаарлалтуудыг зөрчсөн эсхүл зөрчиж болзошгүй нөхцөл үүссэн;
- 2.3.4. Монголбанкнаас баталсан газар дээрх иж бүрэн шалгалтаар банкны үйл ажиллагаа, санхүүгийн байдлыг үнэлэх журам, банкинд зайнаас хяналт тавих аргачлалын дагуу нийлбэр үнэлгээгээр 3-аас дээш үнэлгээ авсан банкинд;
- 2.3.5 Банкны зохистой засаглалын зарчмыг хэрэгжүүлэх журмын дагуу банкны засаглалд эрсдэл учирч болзошгүй эсвэл эрсдэл учирсан нь банкны зохистой засаглалын хэрэгжилтийг үнэлэх үнэлгээний загварын дагуу тогтоогдсон нөхцөлд.
- 2.4. Банкны тусгай зөвшөөрлийн шаардлагыг хангаагүй гэдэгт Монголбанкнаас баталсан банк байгуулах, банкны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журамд заасан шаардлага, шалгуурыг хангахгүй байхыг ойлгоно.

- 2.5. Дараах тохиолдолд банкиг найдваргүй, хэвийн бус үйл ажиллагаа явуулсан гэж үзнэ:
- 25.1. Банкны тухай хууль, тогтоомжид заасан мэдээллийг бүрэн болон хэсэгчлэн гаргаж өгөөгүй, гаргаж өгсөн мэдээлэл нь бодит байдалтай нийцэхгүй, худал, хөндлөнгийн аудитын компаниар аудитын шалгалт хийлгэж, дүгнэлт гаргуулаагүй, хөндлөнгийн аудитын тайлан, мэдээг худал мэдээлсэн;
  - 25.2. Банкны нөлөө бүхий хувьцаа эзэмшигчийн тухай мэдээллийг Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн дагуу Монголбанкинд ирүүлээгүй, олон нийтэд ил тод байдлаар зарлаагүй;
  - 25.3. Хувьцаа эзэмшигчийн эдийн засгийн бусад хэлцлээс шалтгаалан банкны санхүүгийн тогтвортой байдал, харилцах, хадгаламж эзэмшигч нарт сөргөөр нөлөөлөх тухай мэдээллийг Монголбанкинд ирүүлээгүй;
  - 25.4. Банкны төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн нь Банкны тухай хуулийн 32.1, 33.3-д заасан шалгуурыг хангахгүй болсон.
- 2.6. Энэ журмын 2.1-д заасан нөхцөл байдлыг тогтооход санхүүгийн тайлан, үзүүлэлт, нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт, холбогдох этгээдийн шийдвэр зэрэг нотлох баримтыг агуулсан Улсын байцаагчийн эрх бүхий албан тушаалтны тогтоосон акт, мэдэгдэл, ногдуулсан шийтгэвэр, хяналт шалгалтын дүгнэлт зэрэг гарсан байна.
- 2.7. Банкинд урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах шийдвэр гаргах ажиллагааг Захиргааны ерөнхий хуулийн 22 дугаар зүйлд заасны дагуу дараах үндэслэлээр эхлүүлнэ:
- 27.1. Газар дээрх иж бүрэн шалгалтаар банкны үйл ажиллагаа, санхүүгийн байдлыг үнэлэх журмын дагуу хийсэн хяналт шалгалтын материал;
  - 27.2. Зайнаас тавьж байгаа хяналт;
  - 27.3. Банкны үйл ажиллагааны талаар ирүүлсэн гомдол, мэдээлэл;
  - 27.4. Банкнаас ирүүлсэн санхүүгийн тайлан, тэнцэл болон тэдгээртэй холбоотой баримт материалд хийсэн дүн шинжилгээ;
  - 27.5. Хөндлөнгийн аудитын тайлан, удирдлагын захидалд тодорхой дурдсан банкны тухай хууль, тогтоомжийг зөрчсөн зөрчлийн мэдээлэл;
  - 27.6. Үндэсний төлбөр тооцооны системээр дамжуулан хийж буй бэлэн бус төлбөр тооцооны дүн шинжилгээ;
  - 27.7. Банкны бизнесийн үйл ажиллагаа, банкны удирдлага, засаглалын тогтолцооны зохистой байдал, өөрийн хөрөнгийн хүрэлцээ, төлбөр түргэн гүйцэтгэх чадварын талаар холбогдох эрх бүхий этгээдээс гаргасан дүгнэлт;
  - 27.8. Бусад.
- 2.8. Урьдчилан сэргийлэх арга хэмжээ хариуцсан нэгж нь банкинд урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах шийдвэр гаргах ажиллагаанд хамаарах бодит нөхцөл байдлыг тогтоох бөгөөд бодит нөхцөл байдлыг тогтооход ач холбогдол бүхий шаардлагатай ажиллагаа хийх, нотлох баримтыг цуглуулах, үнэлэх үүрэгтэй.

**ГУРАВ. УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭ АВАХ ШИЙДВЭР ГАРГАХ,  
ШИЙДВЭРИЙГ МЭДЭГДЭХ**

- 3.1. Банкинд урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах шийдвэр гаргах ажиллагаа дараах нийтлэг үе шаттай байна.
  - 3.1.1. Энэ журмын 2 дугаар бүлэгт заасан нөхцөл байдлыг холбогдох баримтаар тогтоох
  - 3.1.2. Шийдвэрийн төсөл боловсруулах;
  - 3.1.3. Хууль тогтоомж, энэ журамд нийцэл, шаардлага хангасан эсэхийг хариуцах нэгжийн удирдлага, Монголбанкны удирдлагаар хянуулах, танилцуулах;
  - 3.1.4. Шаардлагатай тохиолдолд сонсох ажиллагаа явуулах;
  - 3.1.5. Энэ журмын 3.4-т зааснаар Банкны хяналт шалгалтын хорооны хурлаар хэлэлцүүлэх;
  - 3.1.6. Шийдвэрийг батлах;
  - 3.1.7. Шийдвэрийг мэдэгдэх.
- 3.2. Урьдчилан сэргийлэх арга хэмжээ хариуцсан нэгж нь Захиргааны ерөнхий хуулийн 28.1-т заасан тохиолдол бий болсныг баримтаар нотолсон тохиолдолд энэ журмын 3.1.4.-т заасан сонсох ажиллагааг явуулахгүй байж болно.
- 3.3. Сонсох ажиллагааг Монголбанкны урьдчилан сэргийлэх арга хэмжээ хариуцсан нэгж явуулах бөгөөд урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах шийдвэр гаргахаас ажлын 3-аас доошгүй өдрийн өмнө энэ журмын 1 дүгээр хавсралтад заасан сонсох ажиллагааны талаарх мэдэгдлийг эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа этгээдэд хүргүүлнэ.
- 3.4. Банкны тухай хуулийн 48.1.14, 48.1.15-д заасан урьдчилан сэргийлэх арга хэмжээг авах санал, Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 27<sup>4</sup>.1.2-т заасны дагуу банкинд хийсэн хяналт шалгалтын тайланг үндэслэн урьдчилсан сэргийлэх арга хэмжээ авах тохиолдолд Банкны хяналт шалгалтын хорооны хурлаар хэлэлцүүлж, шийдвэрлүүлнэ.
- 3.5. Урьдчилан сэргийлэх арга хэмжээ хариуцсан нэгж, Улсын байцаагчийн эрх бүхий албан тушаалтан нь Захиргааны ерөнхий хуульд заасны дагуу банкинд урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах шийдвэрт хувийн хэргийг хөтөлж, шийдвэр бүрт энэ журмын 2 дугаар хавсралтад заасан хяналтын дагалдах хуудсыг хавсаргана.
- 3.6. Улсын байцаагчийн эрх бүхий албан тушаалтан нь урьдчилан сэргийлэх арга хэмжээний шийдвэрийн талаар банк, эсвэл хаяглагдсан этгээдэд ажлын 1 (нэг) өдрийн дотор Захиргааны ерөнхий хуулийн 43.2-т заасан хэлбэрээр мэдэгдэж, ийнхүү мэдэгдсэнээ баримтжуулна.
- 3.7. Монголбанк банкинд урьдчилан сэргийлэх арга хэмжээ авсан тухай өөрийн цахим хуудсаар энэ журмын 3.6-д заасан хугацаанд олон нийтэд танилцуулж болно.
- 3.8. Банкны тухай хуулийн 48.4-т заасны дагуу банкинд урьдчилан сэргийлэх арга хэмжээг авах шийдвэр гарснаас ажлын 1 (нэг) хоногийн дотор Хадгаламжийн даатгалын корпорацад албан бичгээр эсхүл цахим шуудангаар мэдэгдэнэ.
- 3.9. Монголбанк хагас жил бүрийн эхний долоо хоногт өмнөх хагас жилд банкуудад авсан урьдчилан сэргийлэх арга хэмжээний тайланг өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлнэ.

**ДӨРӨВ. УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭГ АВАХ ШИЙДВЭРИЙГ  
ХЭРЭГЖҮҮЛЭХ, ДУУСГАВАР БОЛГОХ**

- 4.1. Урьдчилан сэргийлэх арга хэмжээг энэ журамд заасны дагуу мэдэгдэж хүчин төгөлдөр болсноор хэрэгжүүлж эхэлнэ.
- 4.2. Банкинд энэ журамд заасны дагуу урьдчилан сэргийлэх арга хэмжээ авсан тохиолдолд шийдвэрийн хэрэгжилтийг тогтоосон хугацаанд хангах үүрэгтэй.
- 4.3. Захиргааны ерөнхий хуулийн 83 дугаар зүйлд заасан шаардлага хангасан банкинд урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах шийдвэрт албадлага хэрэглэж шийдвэр гүйцэтгэнэ.
- 4.4. Албадлагыг хуульд зааснаар нэн даруй хэрэглэхээс бусад тохиолдолд албадлага хэрэглэх тухай мэдэгдлийг банкинд бичгээр өгөх бөгөөд уг мэдэгдэлд үүрэг биелүүлэх хугацааг заана.
- 4.5. Мэдэгдэлд заасан хугацаанд банк үүргийг биелүүлээгүй бол Монголбанк Захиргааны ерөнхий хуулийн 86 дугаар зүйлд заасан албадлагын хэлбэрээс сонгон, албадлага хэрэглэхийг шийдвэрлэсэн захиргааны акт гарган, түүнийг нэн даруй биелүүлнэ.
- 4.6. Монголбанкны Ерөнхийлөгч улсын байцаагчийн эрх бүхий бусад албан тушаалтнаас гаргасан шийдвэрийг хууль, журам зөрчсөн, нөхцөл байдал өөрчлөгдсөн зэрэг үндэслэлээр өөрчилж, цуцалж, хүчингүй болгох эрхтэй.
- 4.7. Урьдчилан сэргийлэх арга хэмжээ нь уг арга хэмжээг авах шийдвэрийг цуцалсан, хүчингүй болгосон, эрх бүхий байгууллагын шийдвэр гарсан, шийдвэрт заасан хугацаа дууссан, эсхүл шийдвэрийн биелэлт хангагдсанаар дуусгавар болно.

**ТАВ. БУСАД**

- 5.1. Монголбанкнаас банкинд авсан урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар холбогдох этгээдээс гомдол гаргавал Захиргааны ерөнхий хуульд журмаар шийдвэрлэнэ.
- 5.2. Энэхүү журмыг зөрчсөн этгээдэд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага, хүлээлгэнэ.

## СОНСОХ АЖИЛЛАГААНЫ МЭДЭГДЭЛ

№	Агуулга	Холбогдох мэдээлэл
1.	Сонсох ажиллагааг явуулах журам:	
2.	Сонсох ажиллагаа явуулах он, сар, өдөр, цаг:	
3.	Сонсох ажиллагааг явуулах байрлал:	
4.	Урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах эрх олгосон хууль тогтоомжийн зүйл, заалт:	
5.	Урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах шийдвэр гаргах үндэслэл, мэдээлэл:	

“Банкинд урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах,  
хэрэгжүүлэх журам”-ын хоёрдугаар хавсралт

### ХЯНАЛТЫН ДАГАЛДАХ ХУУДАС

20... оны ... дугаар сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

**Шийдвэрийн дугаар:**

**Шийдвэрийн агуулга:**

**Шийдвэрийн огноо:**

Тайлбар: Дагалдах хуудас нь шийдвэр боловсруулахад оролцсон албан тушаалтан нэг бүрийн хэрхэн оролцсоныг баримтжуулсан байх ёстой.

№	Овог, нэр	Албан тушаал	Шийдвэр гаргахад оролцсон оролцоо, гүйцэтгэл	Санал /Дэмжсэн, дэмжээгүй бол тайлбар бичнэ/	Гарыг үсэг
1.			1. Сонсох ажиллагааны тэмдэглэл хөтөлсөн, 2. Шийдвэрийн төсөл боловсруулсан, 3. Шийдвэрийн төслийн хууль зүйн үндэслэлийг хянасан гэх мэт.		
2.					
3.					
4.					

“Банкинд урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах,  
хэрэгжүүлэх журам”-ын гуравдугаар хавсралт

Арга хэмжээний түвшин	Авах арга хэмжээ	Авах арга хэмжээний төрөл	Өөрийн хөрөнгийн шаардлага			
			Өөрийн хөрөнгийн хүрэлцээ (ӨХХ)	Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн харьцаа (13ӨХ)	Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа (ТТГЧ)	Хөшүүргийн харьцаа (ХХ)
1	48.1.1.зөрчил, дутагдлыг арилгах талаар албан шаардлага тавьж, сануулга өгөх;	Сануулга	(ӨХХ) +2% ~ +3%	(13ӨХ) + 2% ~ +3%	(ТТГЧ) + 2% ~ +3%	(ХХ) + 2% ~ +3%
	48.1.16.Монголбанкнаас шаардлагатай гэж үзсэн бусад арга хэмжээ.	Эрсдэлийн түвшин бага				
2	48.1.2.зөрчил, дутагдлыг арилгах талаар хугацаатай үүрэг, даалгавар өгөх;					
	48.1.3.тогтворжуулах төлөвлөгөөг хэрэгжүүлж, төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг тогтоосон түвшинд хүргэхийг даалгах;					
	48.1.4.банкны өөрийн хөрөнгийг тогтоосон					



	хугацаанд нэмэгдүүлэхийг үүрэг болгох;	Даалгавар өгөх	(ӨХХ) +1% ~ +2%	(13ӨХ) + 1% ~ +2%	(ТТГЧ) + 1% ~ +2%	(XX) +1% ~ +2%
	48.1.5.банкны удирдлага, зохион байгуулалт, үйл ажиллагаа, эрсдэлийн удирдлага, дотоод хяналтыг сайжруулж, бэхжүүлэх арга хэмжээ авахыг даалгах;	- Эрсдэлийн түвшин дунд				
	48.1.8.банкны актив, өр төлбөрийн хэмжээ, өөрчлөлтийг хязгаарлах, эсхүл активыг төрөлжүүлэхийг даалгах;					
	48.1.16.Монголбанкаас шаардлагатай гэж үзсэн бусад арга хэмжээ.					
3	48.1.6. банкны удирдах албан тушаалтны урамшууллын тогтолцоо нь банкны өөрийн хөрөнгийн хангалттай байх түвшинд сөргөөр нөлөөлнө гэж Монголбанк дүгнэсэн бол цалин, урамшууллыг хязгаарлах;	Хязгаарлах - Эрсдэлтэй	(ӨХХ) +0 %~ +1%	(13ӨХ) +0 %~ +1 %	(ТТГЧ) +0 %~ +1 %	(XX) + 0 %~ +1 %
	48.1.7. тодорхой үйл ажиллагаа явуулах, хэлцэл гүйлгээ хийхэд Монголбанкаас					

	<p>урьдчилан зөвшөөрөл авахаар тогтоох;</p> <p>48.1.9.хөрөнгө худалдан авах, банкны нэгж байгуулахыг хориглох;</p> <p>48.1.10.банкны үйл ажиллагаа явуулахыг хэсэгчлэн хязгаарлах, түдгэлзүүлэх;</p> <p>48.1.16.Монголбанкнаас шаардлагатай гэж үзсэн бусад арга хэмжээ.</p>					
4	<p>48.1.10.банкны үйл ажиллагаа явуулахыг бүхэлд нь хязгаарлах, түдгэлзүүлэх;</p>	<p>Албадлагын арга хэмжээ</p> <p>–</p> <p>Өндөр эрсдэлтэй</p>	<p>(ӨХХ)-0% ~ -2%</p>	<p>(13ӨХ) - 0 % ~ - 2 %</p>	<p>(ТТГЧ) - 0 % ~ - 2 %</p>	<p>(XX) - 0 % ~ - 2 %</p>
	<p>48.1.11.хөрөнгө худалдах, банкны нэгжийг татан буулгахыг шаардах;</p>					
	<p>48.1.12.банкны гүйцэтгэх удирдлагыг албан тушаалаас түдгэлзүүлэх, чөлөөлөх;</p>					
	<p>48.1.13.төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх, дуусгавар болгох, чөлөөлөх;</p>					

	48.1.14.энэ хуулийн 48.1.1-48.1.13-т заасан арга хэмжээг банк биелүүлээгүй бол нөлөө бүхий хувьцаа эзэмшигчийн саналын эрхийг түдгэлзүүлэх;					
	48.1.16.Монголбанкнаас шаардлагатай гэж үзсэн бусад арга хэмжээ.					
5	48.1.15.нөхцөлт удирдлагын арга хэмжээ авах;	Бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээ авах  - Эрсэдсэн	(ӨХХ) - 2% >	(13ӨХ) - 2% >	(ТТГЧ) - 2% >	(XX) - 2% >
	48.1.16.Монголбанкнаас шаардлагатай гэж үзсэн бусад арга хэмжээ.					
	48.1.17.энэ хуулийн 27 дугаар зүйлд заасан үндэслэлээр банк байгуулах тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох.					

Арга хэмжээний түвшин	Авах арга хэмжээ	Авах арга хэмжээний төрөл	Төвлөрлийн эрсдэл			Хамгийн том харилцагчийн хадгаламж, харилцахын хязгаарлалт 10%
			Нэг зээлдэгчид олгох зээлийн хязгаар 20%	Банкны холбогдох этгээдэд олгосон зээлийн хязгаар		
				Нэг холбогдох этгээдэд 5%	Нийт 20%	
1	48.1.1.зөрчил, дутагдлыг арилгах талаар албан шаардлага тавьж, сануулга өгөх;	Сануулга	17%-18% байх үед	3.5%-4% байх үед	17%-18% байх үед	8%-8.5% байх үед
	48.1.16.Монголбанкнаас шаардлагатай гэж үзсэн бусад арга хэмжээ.	- Эрсдэлийн түвшин бага				
2	48.1.2.зөрчил, дутагдлыг арилгах талаар хугацаатай үүрэг, даалгавар өгөх;	Даалгавар өгөх - Эрсдэлийн түвшин дунд	18%-19% байх үед	4%-4.5% байх үед	18%-19% байх үед	8%-9% байх үед
	48.1.3.тогтворжуулах төлөвлөгөөг хэрэгжүүлж, төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг тогтоосон түвшинд хүргэхийг даалгах;					
	48.1.4.банкны өөрийн хөрөнгийг тогтоосон хугацаанд нэмэгдүүлэхийг үүрэг болгох;					
	48.1.5.банкны удирдлага, зохион байгуулалт, үйл ажиллагаа, эрсдэлийн удирдлага, дотоод хяналтыг сайжруулж, бэхжүүлэх арга хэмжээ авахыг даалгах;					

	48.1.8.банкны актив, өр төлбөрийн хэмжээ, өөрчлөлтийг хязгаарлах, эсхүл активыг төрөлжүүлэхийг даалгах;					
	48.1.16.Монголбанкнаас шаардлагатай гэж үзсэн бусад арга хэмжээ.					
3	48.1.6.банкны удирдах албан тушаалтны урамшууллын тогтолцоо нь банкны өөрийн хөрөнгийн хангалттай байх түвшинд сөргөөр нөлөөлнө гэж Монголбанк дүгнэсэн бол цалин, урамшууллыг хязгаарлах; 48.1.7.тодорхой үйл ажиллагаа явуулах, хэлцэл гүйлгээ хийхэд Монголбанкаас урьдчилан зөвшөөрөл авахаар тогтоох; 48.1.9.хөрөнгө худалдан авах, банкны нэгж байгуулахыг хориглох; 48.1.10.банкны үйл ажиллагаа явуулахыг хэсэгчлэн хязгаарлах, түдгэлзүүлэх; 48.1.16.Монголбанкнаас шаардлагатай гэж үзсэн бусад арга хэмжээ.	Хязгаарлах - Эрсдэлтэй	19%-20% байх үед	4%-5% байх үед	19%-20% байх үед	9%-10% байх үед
4	48.1.10.банкны үйл ажиллагаа явуулахыг бүхэлд нь хязгаарлах, түдгэлзүүлэх; 48.1.11.хөрөнгө худалдах, банкны нэгжийг татан буулгахыг шаардах;	Албадлагын арга хэмжээ -	21%-23% байх үед	5%-5.5% байх үед	20%-22% байх үед	10%-12% байх үед

	48.1.12.банкны гүйцэтгэх удирдлагыг албан тушаалаас түдгэлзүүлэх, чөлөөлөх;	Өндөр эрсдэлтэй				
	48.1.13.төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх, дуусгавар болгох, чөлөөлөх;					
	48.1.14.энэ хуулийн 48.1.1-48.1.13-т заасан арга хэмжээг банк биелүүлээгүй бол нөлөө бүхий хувьцаа эзэмшигчийн саналын эрхийг түдгэлзүүлэх;					
	48.1.16.Монголбанкнаас шаардлагатай гэж үзсэн бусад арга хэмжээ.					
5	48.1.15.нөхцөлт удирдлагын арга хэмжээ авах;	Бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээ авах	23%-аас их байх үед	7%-аас их байх үед	23%-аас их байх үед	12%-аас их байх үед
	48.1.16.Монголбанкнаас шаардлагатай гэж үзсэн бусад арга хэмжээ.					
	48.1.17.энэ хуулийн 27 дугаар зүйлд заасан үндэслэлээр банк байгуулах тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох.	-	Эрсэдсэн			

Арга хэмжээний түвшин	Авах арга хэмжээ	Авах арга хэмжээний төрөл	Хянан шалгалтын үнэлгээ	Засаглалын үнэлгээ
			CAMELS/ CAEL	Банкны зохистой засаглалын хэрэгжилтийн үнэлгээ
1	48.1.1.зөрчил, дутагдлыг арилгах талаар албан шаардлага тавьж, сануулга өгөх;	Сануулга -	CAMELS-н нийт үнэлгээ нь 3-с дээш эсвэл менежментийн үнэлгээ нь 3-с дээш	Нэгдсэн үнэлгээ 70-79 оноо
	48.1.16.Монголбанкнаас шаардлагатай гэж үзсэн бусад арга хэмжээ.	Эрсдэлийн түвшин бага		
2	48.1.2.зөрчил, дутагдлыг арилгах талаар хугацаатай үүрэг, даалгавар өгөх;	Даалгавар өгөх -		Нэгдсэн үнэлгээ 65-69 оноо
	48.1.3.тогтворжуулах төлөвлөгөөг хэрэгжүүлж, төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг тогтоосон түвшинд хүргэхийг даалгах;			
	48.1.4.банкны өөрийн хөрөнгийг тогтоосон хугацаанд нэмэгдүүлэхийг үүрэг болгох;	Эрсдэлийн түвшин дунд		
	48.1.5.банкны удирдлага, зохион байгуулалт, үйл ажиллагаа, эрсдэлийн удирдлага, дотоод хяналтыг сайжруулж, бэхжүүлэх арга хэмжээ авахыг даалгах;			

	<p>48.1.8.банкны актив, өр төлбөрийн хэмжээ, өөрчлөлтийг хязгаарлах, эсхүл активыг төрөлжүүлэхийг даалгах;</p>	
	<p>48.1.16.Монголбанкнаас шаардлагатай гэж үзсэн бусад арга хэмжээ.</p>	
<p>3</p>	<p>48.1.6.банкны удирдах албан тушаалтны урамшууллын тогтолцоо нь банкны өөрийн хөрөнгийн хангалттай байх түвшинд сэргөөр нөлөөлнө гэж Монголбанк дүгнэсэн бол цалин, урамшууллыг хязгаарлах;</p> <p>48.1.7.тодорхой үйл ажиллагаа явуулах, хэлцэл гүйлгээ хийхэд Монголбанкаас урьдчилан зөвшөөрөл авахаар тогтоох;</p> <p>48.1.9.хөрөнгө худалдан авах, банкны нэгж байгуулахыг хориглох;</p> <p>48.1.10.банкны үйл ажиллагаа явуулахыг хэсэгчлэн хязгаарлах, түдгэлзүүлэх;</p>	<p>Хязгаарлах</p> <p>-</p> <p>Эрсдэлтэй</p>

<p>Нэгдсэн үнэлгээ 55-64 оноо</p>



	48.1.16.Монголбанкнаас шаардлагатай гэж үзсэн бусад арга хэмжээ.			
4	48.1.10.банкны үйл ажиллагаа явуулахыг бүхэлд нь хязгаарлах, түдгэлзүүлэх;	Албадлагын арга хэмжээ  -  Өндөр эрсдэлтэй		Нэгдсэн үнэлгээ 50-54 оноо
	48.1.11.хөрөнгө худалдах, банкны нэгжийг татан буулгахыг шаардах;			
	48.1.12.банкны гүйцэтгэх удирдлагыг албан тушаалаас түдгэлзүүлэх, чөлөөлөх;			
	48.1.13.төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх, дуусгавар болгох, чөлөөлөх;			
	48.1.14.энэ хуулийн 48.1.1-48.1.13-т заасан арга хэмжээг банк биелүүлээгүй бол нөлөө бүхий хувьцаа эзэмшигчийн саналын эрхийг түдгэлзүүлэх;			
	48.1.16.Монголбанкнаас шаардлагатай гэж үзсэн бусад арга хэмжээ.			
5	48.1.15.нөхцөлт удирдлагын арга хэмжээ авах;		-	

	48.1.16.Монголбанкнаас шаардлагатай гэж үзсэн бусад арга хэмжээ.	Бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээ авах -		Нэгдсэн үнэлгээ 49 оноогоос доош
	48.1.17.энэ хуулийн 27 дугаар зүйлд заасан үндэслэлээр банк байгуулах тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох.	Эрсэдсэн		